

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Сэлэнгэ Барилга захиалагч" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/016/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|--|--|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум 2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Баясгалан Утас: 70363047 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|-----------------|--|
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

Агуулга

| | |
|--|-----------|
| 1. Аудитын санал, дүгнэлт | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан | 6 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 6 |
| 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 7 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 8 |
| 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл | 9 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга | 10 |
| 3.1 Байгууллагын үйл ажиллагаа | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд | 11 |
| 3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл | 13 |
| 4. Аудитын тайлан | 13 |
| 4.1. Ерөнхий зүйл | 13 |
| 4.2. Материаллаг байдал | 14 |
| 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 14 |
| 4.3.1 Шилэн дансны мэдээлэл | 14 |
| 4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар | 15 |
| 4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал | 15 |
| 5. Аудитын илрүүлэлт | 15 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 17 |

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 1/1/2024 | 12/31/2024 |
|---------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 376,667,471.10 | 480,767,014.62 |
| 1.1.2 | Дансны авлага | 10,653,148.48 | 52,586,403.48 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | | |
| 1.1.6 | Бараа материал | 2,358,418.16 | 2,510,099.99 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 389,679,037.74 | 535,863,518.09 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 24,519,798.84 | 28,890,956.11 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | | |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 24,519,798.84 | 28,890,956.11 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 414,198,836.58 | 564,754,474.19 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 0.00 | 0.01 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | | |
| 2.1.1.3 | Татварын өр | 14,283,018.07 | 23,213,131.46 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | | 82,499.64 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | | |
| 2.1.1.12 | | | |
| | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 14,283,018.07 | 23,295,631.11 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| | Урт хугацаат өр төлбөрийн дүн | | |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 14,283,018.07 | 23,295,631.11 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч:-төрийн | | |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 399,915,818.51 | 541,458,843.09 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 399,915,818.51 | 541,458,843.09 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 414,198,836.58 | 564,754,474.19 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2023 оны 12 сарын 31 | 2024 оны 12 сарын 31 |
|---------------|------------------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 268,454,544.55 | 263,157,783.91 |
| 2 | Борлуулалтын өртөг | | |
| 3 | Нийт ашиг(алдагдал) | 268,454,544.55 | 263,157,783.91 |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүгийн орлого | | |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |

| | | | |
|------|---|----------------|----------------|
| 8 | Бусад орлого | | |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | | |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 125,352,403.73 | 118,999,331.81 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 58,288.00 | 1,185,700.00 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | | |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 143,043,852.82 | 142,972,752.10 |
| 19 | Орлогын татварын зардал | 1,451,304.67 | 1,453,441.52 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 141,592,548.15 | 141,519,310.58 |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | | |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 141,592,548.15 | 141,519,310.58 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 23.3 | Бусад олз (гарз) | | |
| 24 | Орлогын нийт дүн | 141,592,548.15 | 141,519,310.58 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | | |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|--|-----|------------------------|-------------------------------------|---------------------------|--------------------|----------------|
| 8 | 2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл | | | | | 399,915,818.51 | 399,915,818.51 |
| | 8.1 өмнөх үлдэгдэл | | | | | 399,915,818.51 | 399,915,818.51 |
| | 8.2 Зөрүү | | | | | | |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | |
| 10 | Залруулсан үлдэгдэл | | | | | | |
| 11 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | 141,543,024.58 | 141,543,024.58 |
| 12 | Бусад | | | | | | |

| | | | | | | |
|----|---|--|--|--|----------------|----------------|
| | дэлгэрэнгүй орлого | | | | | |
| 13 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | |
| 14 | Зарласан ногдол ашиг | | | | | |
| 15 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | |
| 16 | 2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл | | | | 541,458,843.09 | 541,458,843.09 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2023 оны 12 сарын 31 | 2024 оны 12 сарын 31 |
|---------------|---|-----------------------|------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 306,452,491.00 | 242,759,787.00 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 303,293,644.00 | 242,759,787.00 |
| 1.1.2 | Бусад мөнгөн орлого | 3,158,847.00 | |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 156,229,299.19 | 128,612,343.48 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 64,682,513.00 | 70,616,818.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 17,509,613.78 | 19,468,540.90 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 6,435,450.00 | 5,461,240.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 6,434,800.00 | 4,301,800.00 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 12,402,147.00 | 8,696,900.00 |
| 1.2.6 | Даатгалын төлбөрт төлсөн | 74,250.00 | 96,250.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 30,370,591.41 | 18,539,204.58 |
| 1.2.8 | Бусад мөнгөн зарлага | 18,319,934.00 | 1,431,590.00 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 150,223,191.81 | 114,147,443.52 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.2 | Хүлээн авсан хүүний орлого | | |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | | 10,047,900.00 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | 10,047,900.00 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | (10,047,900.00) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| 3.1.1 | .Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |

| | | | |
|--------------|---|-----------------------|-----------------------|
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | | |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | | |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | |
| 4 | Валютын ханшийн зөрүү | | |
| 5 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 150,223,191.81 | 104,099,543.52 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 226,444,279.29 | 376,667,471.10 |
| 7 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 376,667,471.10 | 480,767,014.62 |

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Үзүүлэлт | Төсөв/ төгрөгөөр/ | Гүйцэтгэл / төгрөгөөр/ | Зөрүү | Хувь |
|----------|--|-----------------------|---------------------------|------------------------|--------------|
| 1 | Нийт орлого/ НӨАТ-гүй/ | 221,823,588.00 | 242,759,787.00 | (20,936,199.00) | 9.0 |
| 2 | Нийт зарлагын дүн | 221,823,588.00 | 139,843,182.48 | 81,980,405.52 | 37.0 |
| 3 | Цалин хөлс | 102,000,000.00 | 65,028,818.00 | 36,971,182.00 | 36% |
| | Үндсэн цалин | 98,000,000.00 | 57,411,580.00 | 40,588,420.00 | 41% |
| | Урамшуулал цалин | 4,000,000.00 | 7,617,238.00 | (3,617,238.00) | (90%) |
| 4 | НДШ-ийн зардал | 12,750,000.00 | 19,468,540.90 | (6,718,540.90) | (53%) |
| 6 | Бараа үйлчилгээний бусад зардал | 107,073,588.00 | 55,345,823.58 | 51,727,764.42 | 48% |
| | Программ хангамжийн зардал | 1,000,000.00 | 1,023,000.00 | (23,000.00) | (2%) |
| | Түлш шатахуун | 15,800,000.00 | 8,454,730.00 | 7,345,270.00 | 46% |
| | Албан томилолт | 8,000,000.00 | 5,388,000.00 | 2,612,000.00 | 33% |
| | Сэлбэг хэрэгсэл | 5,500,000.00 | 2,245,000.00 | 3,255,000.00 | 59% |
| | Шуудан холбоо | 1,500,000.00 | 514,800.00 | 985,200.00 | 66% |
| | Бичиг хэрэг | 7,000,000.00 | 2,154,300.00 | 4,845,700.00 | 69% |
| | Сургалт | 5,000,000.00 | 450,000.00 | 4,550,000.00 | 91% |
| | Нэг удаагийн тэтгэмж | 1,500,000.00 | 200,000.00 | 1,300,000.00 | 87% |
| | Түрээсийн зардал | 5,000,000.00 | 2,214,000.00 | 2,786,000.00 | 56% |
| | Даатгалын зардал | 100,000.00 | 96,250.00 | 3,750.00 | 4% |
| | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 91,732.00 | 8,268.00 | 8% |
| | Эд хогшил, тоног төхөөрөмжийн | 18,500,000.00 | 10,261,560.00 | 8,238,440.00 | 45% |
| | Үйл ажиллагааны бусад зардал | 8,000,000.00 | 1,978,439.00 | 6,021,561.00 | 75% |
| | Үйл ажиллагааны бус бусад зардал | 7,500,000.00 | 1,243,940.00 | 6,256,060.00 | 83% |
| | Аудитын төлбөр | 600,000.00 | 588,000.00 | 12,000.00 | 2% |
| | Аймгийн ЗДТГ-т гэрээний дагуу | 8,203,482.00 | | 8,203,482.00 | 100% |

| | | | | | |
|---|--------------------------------------|----------------|----------------|----------------|-------|
| | Татварт | 13,770,106.00 | 18,442,072.58 | (4,671,966.58) | (34%) |
| 6 | Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал | 143,043,852.82 | 142,972,752.10 | 71,100.72 | |
| 7 | Орлогын албан татвар | 1,451,304.67 | 1,453,441.52 | (2,136.85) | |
| 8 | Татварын дараах ашиг, алдагдал | 141,592,548.15 | 141,519,310.58 | 73,237.57 | |
| 9 | Нийт ажиллагсдын тоо | 9 | 6 | 3 | 33.3% |
| | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100% |
| | Гүйцэтгэх ажилтан | 3 | 3 | - | 100% |
| | ИТА | 5 | 3 | 2 | 40% |

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь Улсын болон аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын зээл тусламжаар хийгдэж буй барилга угсралт, шинэчлэлт засвар, тохижилтын ажилд захиалагчийн хяналт тавихаас гадна хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа иргэн, хуулийн этгээдийн барилгын гүйцэтгэлд Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу гэрээний үндсэн дээр захиалагчийн хяналтыг гүйцэтгэдэг. Мөн барилгын ажлууд дээр төсөвт багтаан чанартай хийц эдлэлээр барилгыг бариулах норм, дүрмийг дагаж мөрдүүлэх болон далдлагдах ажлыг шалгаж баталгаажуулах, гүйцэтгэгч байгууллагаас гаргасан зөрчлийг арилгуулах, ажлын гэрээт хугацааг чанд мөрдүүлэх, барилга байгууламжийг чанартай ашиглалтад оруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ-ын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Засаг Даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 150,555.6 мянган төгрөгөөр буюу 36.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ Өөрчлөлт |
|----------------|----------------|-----------------|--------------------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 376,667.5 | 480,767.0 | 104,099.5 |
| Авлага | 10,653.1 | 52,586.4 | 41,933.3 |

| | | | |
|---|------------------|------------------|------------------|
| Бараа материал | 2,358.4 | 2,510.1 | 151.7 |
| Үндсэн хөрөнгө | 24,519.8 | 28,890.9 | 4,371.1 |
| Нийт хөрөнгийн дүн | 414,198.8 | 564,754.4 | 150,555.6 |
| Өр төлбөр | 14,283.0 | 23,295.6 | 9,012.6 |
| Эздийн өмч | 399,915.8 | 541,458.8 | 141,543.0 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 414,198.8 | 564,754.4 | 150,555.6 |

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 104,099.5 мянган төгрөгөөр өссөн нь 242,759.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 139,843.1 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 52,586.4 мянган төгрөг болж 41,933.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь дараах төсөл, арга хэмжээнүүд дутуу гүйцэтгэгдсэнтэй холбоотой байна.

- "Цэцэрлэгийн засвар" /Жавхлант сум/ 3,700.4 мянган төгрөг,
- "Гудамж талбайн тохижилт" /Ерөө сум/ 1,920.1 мянган төгрөг,
- "Сургуулийн засвар" /Сайхан сум, Номгон тосгон/ 4,009.0 мянган төгрөг,
- "Цэцэрлэгийн цонхны засвар" /Сүхбаатар сум 2-р цэцэрлэг/ 1,015.9 мянган төгрөг,
- "Ариутгах татуургын шугамын засварын шинэчлэл" / Ерөө, Бугант тосгон/ 4,655.2 мянган төгрөг,
- "ЗхЗ сагсан бөмбөгийн талбай" /Сүхбаатар сум, Мандал сумын Хэрх тосгон/ 1,654.8 мянган төгрөг,
- "Гэрэлтүүлгийн ажил" /Цагааннуур сум/ 1,673.6 мянган төгрөг,
- "Номтхан өрхийн эмнэлгийн өргөтгөлийн барилга" / Сүхбаатар сум, 4-р баг Баянхан/ 3,344.4 мянган төгрөг
- "Хүдэр сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэг" 3,651.8 мянган төгрөг,

Бараа материалын дансны үлдэгдэл 2,510.1 мянган төгрөг байгаа нь байгууллагын хөрөнгөөр 10,476.6 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 10,324.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 28,890.9 мянган төгрөг болж өмнөх оноос 4,371.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 2,727.1 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, 6,407.2 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсан болон 4,763.2 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл тооцоноос шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 23,295.6 мянган төгрөг болж 9,012.6 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын өглөг 1,901.6 мянган төгрөгөөр, НӨАТ-ын өглөг 7,050.2 мянган төгрөгөөр, НДШ-ийн өглөг 82.5 мянган төгрөгөөр тус тус өсөж ААНОАТ-ын өглөг 21.7 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Сэлэнгэ аймгийн Засаг дарга баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 221,823.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 221,823.5 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 242,759.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 139,843.1 мянган төгрөгийн зардал гарган, 1,453.4 мянган төгрөгийн орлогын албан татвар тооцож, 141,519.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 242,759.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 20,936.1 мянган төгрөг буюу 9 хувиар давж биелсэн нь аймгийн болон сумдын орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэг болон барилгын гүйцэтгэлд гэрээний үндсэн дээр захиалагчийн хяналтыг гүйцэтгэснээс голлон шалтгаалсан байна

Нийт зардлын гүйцэтгэл 139,843.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 81,980.4 мянган төгрөгөөр буюу 37 хувиар хэмнэгдсэн нь цалин хөлс, шатахуун, албан томилолт, сэлбэг хэрэгсэл, эд хогшил, тоног төхөөрөмж, сургалт, нэг удаагийн тэтгэмж, бусад зардлуудыг хэмнэснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайлангаа Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 24-ний өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 125,352.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,253.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 20 төрлийн 157 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж бичиг хэргийн зардлыг хэмнэсэн
- Цалин хөлсний зардлыг хэмнэж ажилласан
- Бичиг хэргийн зардлыг хэмнэсэн
- Шинэ жил болон бусад баяр ёслолд зардал гаргалгүйгээр зардлуудыг хэмнэсэн зэргээр нийт зардлыг 63.4 хувиар хэмнэн ажилласан байна.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-н үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 ширхэг автомашинд бусад авто тээврийн хэрэгслээс ялгарах тод дэвсгэр өнгө бүхий дугааргүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэлд тод дэвсгэр өнгө бүхий дугаар авах.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 174 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар нийт **13,842.7** мянган төгрөгийн зөрчил илэрч, 1 зөвлөмж өгөгдлөө.

5.1 Зөвлөмж

Анхан шатны баримттай холбоотой:

Илрүүлэлт: Гүйцэтгэх ажлын удирдамж, тайлан, хаана, хэзээ ажилласныг тодорхойлох гарын үсэг зэргээр томилолтын хуудсыг баталгаажуулалгүйгээр нийт 5,388.0 мянган төгрөгийн томилолтын зардал, жолоочийн тооцооны хуудасгүйгээр 8,454.7 мянган төгрөгийн шатахууны зардал буюу анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт **13,842.7** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Хүчин төгөлдөр бус баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Сангийн сайдын маягт, заавар батлах тухай 347 дугаар тушаалын хавсралтын 6.4 дэх “Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл, тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтын дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----|----------|-----------------|--------------------------------------|-----|---|-----|
| | | | | | | | | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэсэн | 1 | 13,842.7 | | | | | 1 | 13,842.7 | | | | |
| Дүн | 1 | 13,842.7 | | | | | 1 | 13,842.7 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|----------|-----|
| | | | | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 4 мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй | 1 | | | | | | 1 | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | | | | | | | | |
| 2 авто тээврийн хэрэгсэлд тод дэвсгэр өнгө бүхий дугаар аваагүй | 1 | | | | | | 1 | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |
| Нийт дүн | 2 | | | | | | 2 | |